

## ГЛОБАЛЬЧЛАЛ БА МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГО

*Б.Батзаяа\**

Эрин зууны гол шинж бол дэлхийн нэгдсэн зах зээл, үндэстэн улсуудын харилцан хамаарлын гүнзгийрэлт, тэдгээрийн технологийн ойртон нягтрал юм. Дэлхий даяарх мэдээлэл, бараа, үйлчилгээ, хөрөнгө, мэдээллийн урсгалын хурдцаас үүсэлтэй интеграцичлал өдөр ирэх тутам нэмэгдэж ирлээ. Олон улсын эдийн засгийн харилцан хамаарал гүнзгийрч, энэ нь улам бүр улсын хилээр тусгаарлагддаг олон хүчин зүйлүүдийг өөрчилж, үндэсний засгийн газрууд нь олон улсын хөрөнгө оруулагчид, валютын наймаачид, капиталын хүчинд буулт хийн, дэлхийн нэг соёлын нөлөөнд нэгдэж, улмаар Даяаршил хэмээх ойлголт, нэр томъёо бий болсон бөгөөд энэхүү феномен нөлөөлөөгүй улс төр, эдийн засаг, нийгэм, байгаль орчин, эрх зүйн салбар хүрээ байхгүй болжээ. Өөрөөр хэлбэл, улс гүрнүүдийн харилцан хамаарал гүнзгийрч, эерэг болоод сөрөг хам шинжүүдийг агуулсан глобаль буюу даяарчлагдсан орчин бий боллоо.

Глобальчлалын эринд Монгол Улсын хөгжил, дэвшил, аюулгүй байдлын гадаад таатай орчинг бүрдүүлэх, дэлхий нийтийн тулгамдсан глобаль асуудлуудыг шийдвэрлэхэд оруулах хувь нэмэр нь Монгол Улсын гадаад бодлого, оновчтой үйл ажиллагаатай шууд холбоотой.

Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалын Нийтлэг үндэслэлийн Хоёрт: “Монгол Улсын гадаад бодлогын зорилт нь тус улс хүн төрөлхтний хөгжлийн жамыг даган бүх улс оронтой найрсаг харилцаатай байж, олон улсын хамтын нийгэмлэгт байр сууриа бэхжүүлэн, бүс нутгийн болон дэлхийн нөлөө бүхий улс гүрнүүдтэй улс төр, эдийн засгийн болон бусад ашиг сонирхлын шүтэлцээ бүхий харилцааны сүлжээ бүрдүүлэх замаар улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бат найдвартай хангах явдал мөн” гэж заасан юм.

### **Монгол Улс ба Дэлхийн хамтын нийгэмлэг**

Сүүлийн жилүүдэд дэлхий дахинд, түүний дотор манай Монгол оронд өрнөсөн гүн гүнзгий өөрчлөлт Монгол Улсад юу авчрав, Монгол Улс дэлхий дахинаа чухам ямар байр суурь эзэлж байна, Монгол төрийн гадаад бодлого залгамж чанараа хадгалахын хажуугаар хэрхэн хувьсаж, монголын ард түмний язгуур эрх ашигт хэрхэн үйлчилж,

\*Б.Батзаяа - ГХЯ-ны ажилтан

глобальчлалын үйл явцыг хэрхэн тусгаж шингээж ирэв гэх зэрэг асуудал зүй ёсоор тавигдаж байна.

“Хүйтэн дайн” төгсгөл болж, дэлхийн улс гүрнүүдийн дийлэнх нь хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлсийг эрхэмлэн ардчилал, хүний эрхийг дээдлэх, тулгамдсан глобаль асуудлуудыг хамтын хүчээр шийдвэрлэх хүсэл эрмэлзэл давамгайлах болсон энэ он жилүүд Монгол Улсын гадаад бодлого, гадаад харилцаанд онцгой байр суурь эзэлж байна.

Энэ хугацаанд Монгол Улс олон шинэ түнш, найз нөхөдтэй боллоо. Монгол орон дэлхийн санхүү, худалдаа, эдийн засгийн байгууллагуудтай өөрийгөө холбоход нэн их ач холбогдол өгсөн. Монгол Улс 1991 онд Дэлхийн Банк, Олон улсын валютын сан, 1993 онд Азийн Хөгжлийн Банкны гишүүн, 1997 онд Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн болсон. Монголд гарсан гүн гүнзгий өөрчлөлтийн ачаар биднийг дэмждэг, хандив тусламж олгодог шинэ бүлэг орон бий болсон. Эдгээр нь Өрнө, Дорнын өндөр хөгжилтэй ардчилсан улс гүрнүүд юм. Японы Засгийн газар, Дэлхий Банкны санаачилгаар 1991 оноос хойш Монголыг дэмжигч хандивлагч орнуудын уулзалт 9 удаа болсноос 6 нь Токиод, 2 нь Улаанбаатарт, 1 нь Парист болов. Олон улсын аюулгүй байдал, хүний эрх, гэмт хэргийн эсрэг тэмцэл, олон улсын худалдаа, тээвэр холбоо, оюуны өмч, далайн эрх, хүрээлэн буй орчин зэрэг салбарын олон талт 75 гэрээ хэлэлцээрт нэгдэн орж, олон улсын эрх зүйн хамгаалалтыг аль болох өргөн эдлэх боломж бүрдэж байна.

### **Даяаршлын эрин дэх Монгол Улсын гадаад бодлого**

Өнөөгийн гадаад бодлого урдынхаас хэд хэдэн үндсэн шинж байдлаараа ялгаатай. Гадаад ертөнц, олон улсын үйл явдлыг Монгол Улс өөрийн нүдээр харж, дүгнэж, явуулах бодлого, байр сууриа бие даан шийддэг болсон явдал гадаад бодлогод гарсан хамгийн чухал өөрчлөлт болно. Гадаад бодлогын гол зорилго нь Монгол Улсын язгуур ашиг сонирхлыг тууштай хамгаалахад чиглэгддэг болсон явдал түүний шинэ агуулга, гол шинжийг илэрхийлж байгаа.

Бид даяаршлын эрин дэх Монгол Улсын гадаад бодлого, дипломат үйл ажиллагаа ямар байх ёстой юм бэ гэдгийг авч үзэхдээ Монгол Улсын аюулгүй байдал, Үндэсний хөгжилд олон улсын таатай гадаад орчин бүрдүүлэхийн тулд чухам ямар үйл ажиллагаа явуулах, ямар асуудлуудад анхаарлаа голлон хандуулах тухайд юуны түрүүн

тунгаан бодох хэрэгтэй болов уу. Иймд дараахь гурван багц асуудлыг хөндөж тавих нь зүйтэй гэж үзэв:

1. Хоёр талын харилцааны үүрэг роль
2. Монгол Улсад шууд хамаарах бүс нутгийн интеграцийн үйл явцад оролцохын ач холбогдол
3. Дэлхий нийтийн асуудлуудыг шийдвэрлэхэд оруулах хувь нэмэр

### 1. Хоёр талын харилцааны үүрэг роль

Монгол Улс Үндэсний аюулгүй байдал, хөгжлийн гадаад таатай орчинг бүрдүүлэх зорилгоо эрхэмлэн хаяа нийлсэн хөрш хоёр их гүрэн, бусад улс орнуудтай тогтоосон найрсаг харилцааг даяаршилд нийтээр өртсөн нөхцөл байдлыг харгалзан хөгжүүлэх зорилт тавьж байна. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тодорхойлсон гадаад бодлогын зорилтууд ч энэ хүчин зүйлийг тооцсон. Хоёр талын харилцааны үндэс суурь хэр бэхжинэ тэр хэмжээгээр Монгол Улс бүс нутгийн интеграцийн үйл явцад өргөн оролцох таатай боломж нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна.

Монгол Улс 1990-ээд оноос бусдаас хараат бус, жинхэнэ бие даасан гадаад бодлого явуулах түүхэн үйл явц эхэлсэн юм. Энэ үед Монголын гадаад бодлогын зорилго, зарчим, чиг хандлагад дорвитой өөрчлөлт орсон юм. Үүнтэй уялдан манай гадаад бодлого, харилцаатай холбогдсон үгсийн санд нэлээд шинэлэг олон үг хэллэг, ухагдахуун орж ирсэн. Тухайлбал, нээлттэй байдал, олон тулгуурт гадаад бодлого, эвсэлд үл нэгдэх бодлого, үндэсний язгуур эрх ашиг, улс төр-дипломатын арга, гадаад бодлогын үзэл баримтлал, цөмийн зэвсэггүй бүс гэх мэт.

Бие даасан гадаад бодлого явуулах нь өөрөө үйл явц учраас хөгжлийнхөө явцад мөн шинэ ойлголт, хэллэг, ухагдахууныг төрүүлэн гаргасаар байна. Үүний жишээ нь “гурав дахь хөрш”, “стратегийн түнш”-ийн асуудал юм.

“Гурав дахь хөрш”-ийн асуудал бол бие даасан гадаад бодлогын нэг чухал тулгуур хүчин зүйл байх ёстой гэж үзэж байна. “Гурав дахь хөрш” гэдгийг газар зүйн ойлголтын хувьд бус, харин улс төр, эдийн засгийн утгаар нь гарган тавьж байгаа юм. “Гурав дахь хөрш” гэдэг ойлголт нь аль нэг тодорхой гуравдагч орныг хэлж байгаа хэрэг биш, харин Монгол Улс зөвхөн хоёр хөршийн хамаарал дор байх ёсгүй, энэ хоёрын нөлөөллийн зохих тэнцвэрийг хадгалахад гурав

дахь хүч буюу “гурав дахь хөрш”-ийн нөлөөлөл байх ёстой гэсэн үзэл бодлоос үүдэлтэй юм. Иймээс “гурав дахь хөрш” гэдэг ойлголт нь Монгол Улсын аюулгүй байдалд нөлөөтэй, манай ардчилал, зах зээлийн харилцааны ижил үнэ цэнэт зүйлийг эрхэмлэдэг, дэлхийн бодлогод дорвитой жин нөлөө бүхий тэргүүлэх хөгжилтэй ардчилсан орнуудын бүлгийг энд голлон оруулж буй хам ойлголт юм.

“Гурав дахь хөрш”-ийн номнол ёсоор аль нэг улсаас хэт хамааралтай буюу хараат байдалд орохоос сэрэмжлэх, өндөр хөгжилтэй орнуудын эдийн засгийн болон бусад сонирхлыг Монголд бий болгон зохистой төвшинд хүргэх бодлого баримтлах зэрэг нь монгол төрийн бодлогыг хэрэгжүүлэх үндсэн хэрэгсэл, гол арга болох юм. Нөгөө талаар “хоёр хөрш+гурав дахь хөрш”-ийн бодлого нь Монгол Улсын олон тулгуурт ерөнхий чиг бодлогын доторхи гол “тулгын гурван чулуу” нь болж байх учиртай юм.

Иймээс Монгол Улсын аюулгүй байдлын асуудал нь зөвхөн хоёр хөршийн харилцааны тухайн үеийн байдлаар нөхцөлдөж байх бус, харин дэлхийн том улс гүрнүүдийн стратегийн сонирхол, оролцоо, хамаарлаас мөн шалтгаалж байх нөхцлийг тайван цагт хангаж чадсан байх явдал манай гадаад бодлогын нэг чухал стратегийн зорилт байх ёстой юм. Иймээс стратегийн түншлэлийн чиг бодлогыг АНУ-аас гадна Япон, Энэтхэг, Европын Холбоо зэрэг дэлхийн бодлогыг тодорхойлогч улс гүрнүүдтэй харилцахдаа баримтлах нь манай улсын язгуур эрх ашигт бүрэн нийцэх учиртай.

## 2. Монгол Улсад шүүд хамаарах бүс нутгийн интеграцийн үйл явцад оролцохын ач холбогдол

Бүс нутаг, салбар бүсийн хэмжээнд өрнөж байгаа эдийн засгийн интеграцийн үйл явц нь улс орнуудын харилцааны улс төрийн ерөнхий уур амьсгал, итгэлцэл, ойлголцол, энх тайван, аюулгүй байдлыг хангах асуудалтай нягт холбоотой. Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалд “...гадаад харилцааны бодлого дотроос улс төрийн гадаад бодлого тодорхойлогч шинжтэй байна” гэж заасан. Энэ ч үүднээс тус бүс нутагт янз бүрийн шугамаар явагдаж байгаа олон талт улс төрийн яриа хэлэлцээнд идэвхитэй оролцож, бүс нутгийн аюулгүй байдлыг хангахад хувь нэмрээ оруулах нь манай гадаад бодлогын чухал чиглэл.

XXI зууныг Ази, Номхон далайн зуун болно гэж судлаачид үзэж байгаа билээ. Монгол Улс салбар бүсүүдийн төдийгүй тус бүсийн хэмжээнд өрнөж байгаа өргөн хүрээтэй интеграцийн үйл явцад оролцох

нь гадаад бодлогын нэн чухал чиг шугам байх учиртай. Монгол Улс Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага - АПЕК-д элсэх асуудал нь Монгол Улсын гадаад бодлогын урт хугацааны нэг зорилт мөн. Монгол Улс АПЕК-ийн гишүүнчлэлийн мораториум дууссаны дараа энэ байгууллагад элсэх хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн. Тус байгууллагад гишүүнээр элсэх шалгуур үзүүлэлтүүдийг манай улс бүрэн хангах бололцоотой юм. 1999 оны байдлаар, манай улс дэлхийн 70 орчим оронтой худалдааны харилцаатай болсон бөгөөд түүний эргэлтийн 86 хувь, Монголд оруулж байгаа гадаадын хөрөнгө оруулалтын 70 хувь нь АПЕК-ийн гишүүн орнуудад ноогдож байв. Монгол Улс Ганцаарчилсан үйл ажиллагааны төлөвлөгөөг АПЕК-ийн жишгийн дагуу боловсруулж хууль тогтоох байгууллагаараа батлуулаад ажиллаж байна. Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны Үндэсний хороо гэгдэх төрийн бус байгууллага (МОНКПЕК) 1998 онд байгуулагдаж, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны зөвлөлд (ПЕКК)-д Монгол Улс 2001 оны 4 дүгээр сард элслээ. Үүнийг манай АПЕК-д элсэх асуудал нэг шатаар урагшилсан гэж үзэж болно. Түүнчлэн манай улс АПЕК-ийн 4 ажлын хэсэгт ажиглагчийн статустай оролцож байна.

Бүс нутгийн яриа хэлэлцээний нэг гол механизм болох АСЕАН-ы Бүсийн чуулга (АРФ)-д Монгол Улс 1998 онд нэгдэн орсон. Энэ нь Монгол Улсыг Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдлын асуудлаар яриа хэлэлцээнд байнга оролцох боломжийг нээж өгсөн өөрөө Ази, Номхон далайн бүс нутагт идэвхтэй үйл ажиллагаа явуулахад чиглэсэн манай улсын гадаад бодлогын нэг чухал ололт гэж үзэж болно.

Монгол Улс бодит боломж нөхцлийнхөө хэрээр АРФ-ын үйл ажиллагаанд идэвхтэй, тогтмол оролцож, хувь нэмрээ оруулахыг эрмэлзэж байдаг. АРФ-ын үйл явц 2001 оноос эхлэн урьдчилан сэргийлэх дипломат үйл ажиллагааны чиглэлд дэвшин орж буйд Монгол Улс сэтгэл ханамжтай байгаа бөгөөд энэ чиглэлээр явуулах үйл ажиллагааны зарчим, үзэл баримтлалыг гишүүн орнуудын саналыг харгалзан боловсруулах шаардлагатай гэж үздэг.

Манай улс АРФ-д нэгдэн орсноос хойш уг үйл явцын ажлын механизм болох сайд нарын, ахлах албан тушаалтны болон ажлын хэсгийн уулзалтуудад тогтмол оролцож байна. Бид гадаад бодлогынхаа залгамж чанарыг хадгалан АРФ-ын үйл ажиллагаанд цаашдаа ч идэвхтэй оролцох байр суурийг баримталдаг.

Энэ дашрамд тэмдэглэхэд, Монгол улс Зүүн Хойд Азийн орон учраас энэ дэд бүс нутагт өрнөж буй үйл явц манай үндэсний аюулгүй байдалд гүн гүнзгий нөлөө үзүүлэх болно гэж үздэг. ЗХА-ийн салбар бүс нутагт эдийн засгийн олон талт хамтын ажиллагаа хөгжих нэг нөхцөл бол аюулгүй байдлын тогтвортой орчин, нөгөө талаас аюулгүй байдлыг тогтворжуулж, итгэлцэл, харилцан ойлголцлыг гүнзгийрүүлэхэд эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх асуудалд өндөр ач холбогдол өгч ирэв.

ОХУ-ын Сибирь, Алс Дорнод, БНХАУ, ЗХА-ийн бусад орныг холбох өндөр хүчдэлийн шугам, газрын тос, байгалийн хий дамжуулах хоолой байгуулах төсөл зэрэг томоохон төслүүд нь ЗХА-ийн орнуудын хооронд эдийн засгийн интеграцийг хөгжүүлэхэд түлхэц болох боломжтой. Эдгээр төсөлд хамрагдах сонирхол бидэнд бий. Манай улс хөрш хоёр оронтойгоо гурван талт хамтын ажиллагаа хөгжүүлэх, БНАСАУ-ыг бүс нутаг болон дэд бүсийн эдийн засгийн хамтын ажиллагаанд татан оролцуулахыг зорьдог.

Тус дэд бүс нутгийн хүрээнд НҮБ-ын шугамаар 10 гаруй жил хэрэгжиж буй “Түмэн голын сав нутгийг хөгжүүлэх” төсөлд манай улс хамрагдаж, уг төслийг амжилттай урагшлуулах үүднээс нилээд хүчин чармайлт тавьж ирэв. Эл төсөл ЗХА-ийн орнуудын хооронд эдийн засгийн харилцааг өргөжүүлэх, ялангуяа дэд бүцийн салбарт хамтын ажиллагааг хөгжүүлэх өргөн потенциалтай гэж бодож байна. Энэ нь Засгийн газрын шугамаар явагдаж байгаа төсөл гэдэг утгаараа онцлог ач холбогдолтой. Мөн Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссийн хүрээнд хэрэгжүүлж буй Транс-Азийн төмөр зам, авто замын сүлжээний төсөлд идэвхитэй оролцохыг эрмэлзэж байгаа.

ЗХА-ийн бүс нутгийн хэмжээнд аюулгүй байдлын асуудлаар яриа хэлэлцээг засгийн газрын түвшинд хийх саналыг манай улс НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 55 дугаар чуулганы үеэр дэвшүүлж, энэ чиглэлээр холбогдох улс орнуудтай ажиллаж байна.

Манай улс Азид хамтын хүч чармайлтаар аюулгүй байдлыг бататгах, хамтын ажиллагааг хөгжүүлэх санал санаачилгуудыг дэмжиж, хүч чармайлтаа нэгтгэж байна. Азид хамтран ажиллах, итгэлцлийг бэхжүүлэх асуудлаар 2002 оны 6 дугаар сард Алматы хотноо болсон дээд хэмжээний анхдугаар зөвлөлгөөн, түүнээс гаргасан баримт бичгүүд (Алматын акт, Иргэншил хооронд яриа хэлцэл өрнүүлэх, терроризмыг үндсээр нь устгах тухай Тунхаглал) нь тус тивийн улс гүрнүүд аюулгүй байдал, хамтын ажиллагааны зорилтуудыг хамжин шийдвэрлэх хүсэл

эрмэлзлийг илтгэн харууллаа. Мэдээж Европын жишээг Азийн хөрсөнд буулгах асуудал, Төв Азийг цөмийн зэвсэггүй бүс болгох тухай санал санаачилгыг хэрэгжүүлэх нь манай аюулгүй байдалд хамааралтай гэдгийг бид эш үндэс болгож байх учиртай.

Төв Азийн аюулгүй байдал, хамтын ажиллагааны өргөн хүрээтэй асуудлыг хэлэлцдэг “Шанхайн тав” хэмээх чуулга уулзалтыг бид анхааралтай ажиглаж үйл ажиллагаанд нь ямар нэг хэлбэрээр оролцох асуудлыг судалж байна.

Үүнээс гадна Монгол Улс 2003 оны 5 дугаар сард Ташкентэд болох уулзалтаар Европын сэргээн босголт, хөгжлийн банкны бүрэн эрхт гишүүн болоход бэлэн болоод байна. Ингэснээр Монгол Улс зээл болон хөрөнгө оруулалтын хувьд боломжтой болох юм.

### 3. Дэлхийн нийтийн асуудлуудыг шийдвэрлэхэд орчуулах хувь нэмэр

Өнгөрсөн зуунаас хуримтлагдсан 21 зуунд улам бүр шинж чанар нь ноцтой болж хувирч байгаа глобаль асуудлууд хүн төрөлхтний өнөөгийн болоод ирээдүйн хувь заяаг шууд хөндөж, сэтгэл түгшээж байна. “Дэлхийн хүрээлэн буй орчин улам доройтож, хэрэгжүүлж буй арга хэмжээ нь хангалтгүй хэвээр байна. Хөгжиж буй орнуудын хувьд ядуурлыг бууруулах, даяаршлын хүрээнд дорвитой амжилт олсонгүй, түүнчлэн дэлхийн хүн ам даяаршлын үр шимийг тэгш хүртэж чадахгүй байна” гэдгийг НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Кофи Аннан даян дэлхийн 21 дууны хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх илтгэлдээ тэмдэглэсэн байна. Олон улсын терроризм улс түмний аюулгүй байдал, энх амгалан байдалд ноцтой занал учруулах боллоо. Энэ нь мөн л ядуурал, хөгжлийн хоцрогдол, үндэсний “ганцаардал” зэрэг зүйлүүдтэй холбоотой. Эдгээр нь хэт гажуудсан сэтгэхүй, үйлдлийг тэжээгч шимт хөрс болж хувирах аюулыг хүлээн зөвшөөрч терроризмын эсрэг тэмцлийг зөвхөн зэвсгийн хүчинд дулдуйдалгүй, дорой буурай нэгнийхээ хөгжил, дэвшлийг хангахад нийтээр анхааран идэвхтэй дэмжлэг туслалцаа үзүүлэн эгнээндээ татан авах нь асуудлыг шийдэх үр дүнтэй арга юм.

Монгол Улс дэлхийн хамтын нийгэмлэгийн өмнө тулгарч байгаа эдгээр болон бусад сорилтыг даван туулахад хүч болоцоо, туршлагадаа тулгуурлан гадаад бодлогын үйл ажиллагаагаа чиглүүлж, хувь нэмрээ оруулахыг зорьж байна. Монгол Улс НҮБ-ын идэвхтэй оролцоо, дэмжлэгтэйгээр “Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал

хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж байгаа анхны орон. Энэ чиглэлээр Монгол Улстай хамтарч ажилласан туршлагаа НҮБ хөгжиж буй бусад гишүүн оронд нэвтрүүлэх зорилготой. Иймээс энэхүү хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх нь манай улсын нэр хүндийг өргөөд зогсохгүй бусад хөгжиж байгаа оронд хүртээлтэй үйлс болох юм.

Өнөөдөр Монгол Улсын гүйцэтгэх үүрэг урьд өмнөхөөс илүү чухал болоод байна. Улс орнууд өнөөгийн даяаршлын эринд эрчимтэй өрнөж байгаа өөрчлөлт шинэчлэлтэй мөр зэрэгцэн алхаж гэрээ амьдрах чадвартай эдийн засгийг бий болгож, хүмүүсийн бүтээлч идэвхи санаачилгыг чөлөөтэй өрнүүлэх хэрэгтэй юм. Хүрээлэн буй орчны доройтол, мансууруулах бодисын наймаа, ДОХ мэтийн өвчин эмгэгийн тархалт зэрэг асуудлууд хил хязгааргүй болсон тул улс орнууд өмнөх үеэсээ илүү нягт хамтран ажиллах шаардлагатай байна.

Эдүгээ дэлхийн улс орнуудын харилцан хамаарал гүнзгийрч, олон улсын эдийн засаг, аюулгүй байдлын шинэ орчин үүсч байна. НҮБ-ын хүрээнд Монгол Улс идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. НҮБ бол Монгол Улсын аюулгүй байдлын чухал баталгаа мөн. НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын бус гишүүний 2009-2010 оны суудалд бид нэрээ дэвшүүлсэн бөгөөд энэ сонгуульд амжилттай оролцохын тулд одооноос төлөвлөгөө тооцоотой ажиллаж байна.

Зэвсэг хураах чиглэлд бидний гаргаж байгаа хүчин чармайлтын хувьд 1992 онд Монгол Улс өөрийн нутаг дэвсгэрийг цөмийн зэвсэггүй бүс болгон зарласан. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 53, 55 дугаар чуулганаар “Монгол Улсын олон улсын аюулгүй байдал, цөмийн зэвсэггүй статус”-ын тухай тогтоолыг баталсан нь манай улсын аюулгүй байдлын баталгааг бэхжүүлэхэд чиглэсэн чухал арга хэмжээ болсон юм. “Цөмийн зэвсгээс ангид байх тухай” Монгол Улсын хуулийг УИХ-аар баталж Монгол Улсын цөмийн зэвсэггүй статусын асуудлаар НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын таван гишүүн хамтарсан мэдэгдэл гаргасан.

Даяаршлын эринд дэлхийн хамтын нийгэмлэгийн өмнө тулгарч байгаа нийгэм, эдийн засгийн асуудлуудыг хамтын хүчээр шийдвэрлэх хэрэгт манай улс нийтийн анхаарлыг хандуулж, Монгол Улсын санаачилгаар НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2003-2012 оныг Бичигтэн болох НҮБ-ын 10 жил болгон зарласантай холбогдуулан ЮНЕСКО-гоос НҮБ-ын Нарийн бичгийн дарга нарын газартай хамтран энэ оны 2 дугаар сарын 13-нд Нью-Йорк хотноо Бичигтэн болох 10 жилийн нээлтийг зарласан. Мөн нийгмийн хөгжилд хоршооллын

гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх, хөдөөгийн эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах тухай тогтоолыг батлуулсан. Эдгээр чиглэлээр дэлхий нийтийн хэмжээнд ахиц дэвшил гаргах нь тогтвортой хөгжлийг хангах нөхцлүүдийн бүрэлдэхүүн хэсэг болох нь дамжиггүй.

Солонгосын хойгийн хэрэг явдал нь Монгол Улсын хувьд сонирхлын бус амин чухал, үндэсний эрх ашгийн асуудал. Учир нь БНСУ Монголын хоёр дахь том хөрөнгө оруулагч, худалдааны тавдагч түнш төдийгүй гадаадад ажиллан амьдрагч монголчуудын дийлэнх нь тэнд суудгаараа, Монгол иргэдийн хувь заяа тэрхүү бүс нутагтай холбоотой. Тус бүс нутгийн статус-квог хадгалах ёстой, гэхдээ статус-кво нь цөмийн зэвсэггүй байх хэрэгтэй гэж Ерөнхийлөгч Н.Багабанди хэлсэн билээ. Ингэхдээ Солонгосын хойгийн асуудлыг яриа хэлэлцээний замаар шийдэх орон зай, цаг хугацааны боломж бий, мөн аливаа улсыг ганцаардуулах, бусдаас таслах бус аль болох бүс нутгийн хамтын ажиллагаанд татан оролцуулах замаар асуудлыг шийдвэрлэх байр суурьтай байгаа билээ.

Иракийн асуудлын талаар Монгол Улс цөмийн зэвсэггүй бүсийн статустай тул манай улсын баримталж буй бодлого хуулийн хүрээнд тодорхой юм. Хэрвээ зэвсэгтэй бол түүнээс ангижрах, зэвсэг үл дэлгэрүүлэх гэсэн байр суурьнаас хандаж байна.

Глобалчлалын асуудлаар Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн, 77-гийн бүлгийн хүрээнд хөгжлийн түвшингээр адил төстэй улс орнуудтай хамтран ажиллах нь манай гадаад бодлогын чухал чиглэл. Малайз улсын Куала Лумпур хотноо энэ оны 2 дугаар сарын 24-25-нд болсон Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний XIII дээд хэмжээний чуулга уулзалтад манай улс дээд хэмжээнд оролцов.

Олон талын дипломатын хажуугаар бүс нутаг, салбар бүсийн хэмжээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулснаар бүх нийтийн аюулгүй байдал, хамтын ажиллагаанд, цаашлаад даяаршлын үйл явцыг тайван нөхцөлд, нааштай залж чиглүүлэхэд Монгол Улс хувь нэмрээ оруулж чадах юм.

Монгол Улсын аюулгүй байдал, хөгжил цэцэглэлийг хангах үүднээс бүс нутаг болон дэлхийн нөлөө бүхий улс гүрнүүдтэй улс төр, эдийн засгийн болон бусад ашиг сонирхлын шүтэлцээ бүхий харилцааны сүлжээ бүрдүүлэх, хөгжлийн төлөө хамтран ажиллах нь манай гадаад бодлогын тэргүүлэх зорилтын нэг билээ.